

**ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
2025 ОНЫ 3-Р УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

Зорилго: Орон нутгийн өмчийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, удирдлагыг сайжруулах, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд оршино.

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)	Гүйцэтгэлийн хувь
Зорилт 1.Төрийн болон орон нутгийн өмчийн холбоотой хууль, бусад хууль, тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах:							
1	Арга хэмжээ 1.1 Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 204 дүгээр тогтоолын 3 болон 9 дэх заалтын хэрэгжилтийг хангах	БӨХ	Тогтоолын хэрэгжилт, тайлагналтын хувь	100%	100%	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоолын 2 заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийн 1 заалтын хэрэгжилтийг ханган төрийн цахим мэдээллийн системээр дамжуулан 2 удаа тайлагнасан байна. “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын 3 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд: - Аймгийн ИТХ-ын “Үндсэн хөрөнгийн дуудлага худалдаагаар борлуулах” 2024.12.25 А/55/ тоот захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж 6 тээврийн хэрэгслийг 2025 оны 02-сарын 14 өдөр нээлттэй дуудлага худалдаагаар боруулан 33,0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. - Аймгийн ИТХ-ын “Үндсэн хөрөнгийн дуудлага худалдаагаар борлуулах” 2025.03.21 А/23 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж 5 тээврийн хэрэгслийг 2025 оны 05-р сарын 28-ны өдөр нээлттэй дуудлага худалдаагаар худалдан борлуулж орон нутгийн төсөвт 14,0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. - Аймгийн ИТХ-ын “Нээлттэй дуудлага худалдаа зохион байгуулах тухай” 2025.08.11-ний А/72 тоот захирамжийн	100%

						хэрэгжилтийг ханган ажиллаж 19 тээврийн хэрэгслийн дуудлага худалдааг 11-р сард зохион байгуулахаар зарыг нийтэд хүргүүлсэн байна. Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоолын 9 дэх заалтыг зөрчсөн үйлдэл гараагүй байна.	
2	Арга хэмжээ 1.2 Орон нутгийн өмчийн харилцааг зохицуулах журмуудыг хуульд нийцүүлэн шинэчлэн мөрдөх.	БӨХ	Хэрэгжилт, тайлагналтын хувь	0	100%	Байгууллагын стратеги төлөвлөгөө болон байгууллагын дүрмийг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчилж мөрдөн ажиллаж байна. 2018 оны 5-р сарын 1-ний Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 25-р тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах” журмыг шинэчлэн өөрчилж батлуулахаар ажиллаж байна.	70%
3	Арга хэмжээ 1.3 Төрийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын мөрөөр авах арга хэмжээг хэрэгжүүлж газрын маргаан, зөрчлийг арилгуулах (Засгийн газрын 2022 оны 481 дүгээр тогтоол)	БӨХ	Шийдвэрлэсэн зөрчлийн тоо	55	55	Засгийн газрын 2022 оны 481 дүгээр тогтоолын дагуу газрын зөрчил маргааныг арилгуулах арга хэмжээг авч ажиллан маргаан нь шийдвэрлэгдээгүй үлдсэн 15 газрын маргааныг шийдвэрлэн ажилласан байна.	70%
4	Арга хэмжээ 1.4 Төрийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын мөрөөр авах арга хэмжээг хэрэгжүүлж маргаантай хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх (Засгийн газрын 2022 оны 481 дүгээр тогтоол)	БӨХ	Шийдвэрлэсэн хөрөнгийн тоо	7	7	Энэ арга хэмжээг IV улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн тул хүлээгдэж байна.	-
Зорилт 2. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтыг удирдлага, зохицуулалтаар хангах, бүртгэл хөтлөх, тооллого зохион байгуулах, хяналт тавих:							
5	Арга хэмжээ 2.1 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн жилийн эцсийн санхүүгийн тайлан,эд хөрөнгийн	БӨХ	хуулийн этгээдийн тоо	276	276	- Орон нутгийн өмчит 196 байгууллага, 82 сангийн 314,6 тэрбум төгрөгийн мэдээ тайланг хүлээн авч, өмчийн бүртгэл болон э-тайлантай тулган баталгаажуулж 2025 оны 05-р сард Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын	100%

	хөдлөл өөрчлөлтийн тайланг хүлээн авч хянах нэгтгэх					газрын Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтсийн бүртгэлтэй тооцоо нийлж баталгаажууллаа.	
6	Арга хэмжээ 2.2 Төрийн болон орон нутгийн өмчит төрийн байгууллага, хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөний зохицуулалтыг удирдлагаар хангах	БӨХ	Эд хөрөнгийн зохицуулалтын хүсэлтийн шийдвэрлэлтийн хувиар	100%	100%	- 2025 оны эхний хагас жилд дараах өмчийн өөрчлөлт, хөдөлгөөний хэрэгжилтийг ханган ажиллалаа. ➤ Аймгийн ИТХ-ын даргын “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 2025.03.21 А/22/ тоот захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж 4 байгууллагын 257.0 сая төгрөгний балансын дүнтэй, 86,3 сая төгрөгний хуримтлагдсан элэгдэлтэй, 170,6 сая төгрөгний үлдэгдэл өртөгтэй 2 хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн. ➤ Аймгийн ИТХ-ын даргын “Үндсэн хөрөнгийн дуудлага худалдаагаар борлуулах” 2024.12.25 А/55/ тоот захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж 6 байгууллагын 170,9 сая төгрөгний балансын үнэ бүхий 158,5 сая төгрөгний хуримтлагдсан элэгдэлтэй, 12,3 сая төгрөгний үлдэх өртөгтэй цаашид ашиглах боломжгүй болсон 6 тээврийн хэрэгсэл, 1 соёлын төвийн дүнзэн барилгыг 2025 оны 02-сарын 14 өдөр нээлттэй дуудлага худалдаагаар оруулан 33,0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. ➤ Аймгийн ИТХ-ын даргын “Үндсэн хөрөнгийн дуудлага худалдаагаар борлуулах” 2025.03.21 А/23 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж 4 байгууллагын 120,7 сая төгрөгний балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий анхны өртгөөрөө хуримтлагдсан элэгдлээ нөхсөн цаашид ашиглах боломжгүй болсон 5 тээврийн хэрэгслийг 2025 оны 05-р сарын 28-ны өдөр нээлттэй дуудлага худалдаагаар худалдан борлуулж орон нутгийн төсөвт 14,0 сая төгрөгийг төвлөрүүлсэн. ➤ Аймгийн ИТХ-ын даргын “Үндсэн хөрөнгө акталж, хоёрдогч түүхий эдээр ашиглах зөвшөөрөл олгох тухай” 2025.03.21 А/24 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган Эрүүл мэндийн газрын 73.0 сая төгрөгний балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий анхны өртгөөрөө хуримтлагдсан элэгдлээ бүрэн нөхсөн цаашид ашиглах	100%

					боломжгүй болсон 2 тээврийн хэрэгслийг 2,0 сая төгрөгөөр худалдан борлуулан эрүүл мэндийн газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн. ➤ Аймгийн ИТХ-ын “Аймгийн ИТХ-ын Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 2025.03.21 А/25 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж орон нутгийн өмчит 14 байгууллагын 768,6 сая төгрөгний балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий анхны өртгөөрөө хуримтлагдсан элэгдлээ нөхсөн цаашид ашиглах боломжгүй болсон 837 нэр төрлийн хөрөнгийг акталж, данснаас хасах хүсэлтийг шийдвэрлэсэн. ➤ Аймгийн ИТХ-ын “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 2025.08.11-ний А/71 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж 142,972,724 төгрөгийн балансын үнэтэй, 114,271,903.78 төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг удирдлагаар ханган ажилласан. ➤ Аймгийн ИТХ-ын “Үндсэн хөрөнгө актлах, хоёрдогч түүхий эдээр ашиглах тухай” 2025.09.18-ний А/82 тоот захирамжийн дагуу 26,890,000 төгрөгийн балансын үнэтэй элэгдлээ бүрэн байгуулсан 0 төгрөгийн үлдэх өртөгтэй үндсэн хөрөнгийг актлах ажлыг удирдлагаар ханган ажилласан. ➤ Аймгийн ИТХ-ын 2025.09.18-ний А/83 “Үндсэн хөрөнгө актлах, данснаас хасах тухай” захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж 13,733,280 төг балансын үнэтэй, 3,862,485 төгрөгийн элэгдэлтэй үндсэн хөрөнгийг данснаас хасах ажлыг зохион байгуулсан. Эдгээр хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу данс бүртгэлээс хасах, данс бүртгэлд тусгах ажлыг хянаж нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд” бүртгэсэн.	
--	--	--	--	--	--	--

7	Арга хэмжээ 2.3 Орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г дүгнэх, сунгах ажлыг зохион байгуулах	БӨХ	Хуулийн этгээдийн тоо	194	150	Отгон, Шилүүстэй, Цагаанчулуут, Цагаанхайрхан, Яруу, Эрдэнэхайрхан, Улиастай сумдын нийт 80 орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ ”-г дүгнэх, сунгах ажлыг зохион байгуулсан.	70%
8	Арга хэмжээ 2.4 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн түрээсийн гэрээг шинэчлэн байгуулах, сунгах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэнд хяналт тавих	БӨХ	Төсвийн орлогын төлөвлөгөө /сая төг /	23.5	19.0	- Орон нутгийг өмчийг түрээсээр эзэмшүүлэх нийт 18 байгууллагын гэрээг шинэчлэн байгуулж 2025 оны 3-р улирлын байдлаар нийт 5,3 сая төгрөгийн түрээсийн орлогыг орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлсэн байна.	100%
9	Арга хэмжээ 2.5 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, илүүдэлтэй , ашиглалтгүй хөрөнгийг худалдах ажлыг зохион байгуулах	БӨХ	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дуудлага худалдааны орлого /сая төг/	18.0	20.0	2025 оны эхний хагас жилд 2 удаа нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулж нийт 13 үлдэх өртөггүй хөрөнгийг худалдан борлуулж орон нутгийн төсөвт 47,0 сая төгрөг, аймгийн Эрүүл мэндийн газрын дансанд 2,0 сая төгрөг төвлөрүүлсэн байна.	100%
10	Арга хэмжээ 2.6 Орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийх хяналт шалгалтын төлөвлөгөө гаргаж батлуулан мөрдөн ажиллах.	БӨХ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	100%	100%	2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу эхний хагас жилд баримтын иж бүрэн шалгалтыг 4 байгууллагад, системийн хяналт шалгалтыг 11 байгууллагад, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг нийт 30 байгууллагад хийсэн байна. Хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг хүргүүлэн ажиллаж байна.	100%

Зорилт 3. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үр ашгийг дээшлүүлэх, компанийн засаглалыг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах:

11	Арга хэмжээ 3.1 Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд шинжилгээ хийж, арга зүй, зөвлөмжөөр ханган ажиллах	БӨХ	Өгсөн зөвлөмжийн тоо	0	2	Орон нутгийн өмчит “Очир илч” ХХК, Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төв” ТҮГ-ын 2023, 2024 оны санхүү, эдийн засгийн байдалд хяналт шинжилгээ хийж, үр өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд 2 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. Монгол улсын сайд, ЗГХЭГ-ын даргын аймгийн Засаг даргатай байгуулсан “Хуульд заасан төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээ”-ний заалт болон “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх болон Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн үр өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, ХХК-иудад үүрэг чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллах талаар байгууллага бүрийн удирдлага, холбогдох хүмүүстэй уулзаж зөвлөмж, чиглэлийг өгч ажиллалаа.	100%
12	Арга хэмжээ 3.2 Орон нутгийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг мэргэжил, арга зүйгээр хангах	БӨХ	Өгсөн зөвлөмжийн тоо	0	2	Хүлээгдэж байна.	-
13	Арга хэмжээ 3.3 Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нийтэд мэдээлэх шаардлагатай	БӨХ	Мэдээллийн төрлийн тоо	5	8	Завхан аймагт нийт 7 орон нутгийн өмчит хуулийн этгээд үйл ажиллагаагаа явуулж байгаагаас 2 нь ХХК, 3 нь ААТҮГ, 2 нь ТҮГ хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн мэдээллийн нээлттэй байдлыг хангах үүднээс мэдээллийг нэгдсэн байдлаар болон хуулийн этгээд бүрээр бэлтгэн аймгийн /www.zavkhan.gov.mn/ , албан ёсны сайтын “ил тод байдал”-ын “бусад хэсэг”-т /ЗАВХАН АЙМАГ ЗДТГ ЗАВХАН АЙМАГ ЗАВХАН zavkhan zavkhan/ болон өөрийн байгууллагын www.umch.za.gov.mn /Ерөнхий мэдээлэл – Завхан аймгийн Орон нутгийн өмчийн газар/ сайтад тухай бүр шинэчлэн байршуулж нийтэд мэдээлж байна.Үүнд: - Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компанийн хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ https://umch.za.gov.mn/?page_id=251	100%

мэдээллийг нээлттэй ил тод болгох ажлыг удирдлага, арга зүйгээр ханган ажиллах					- Орон нутгийн өмчит газруудын ашиг алдагдлын мэдээлэл 967fedfc7164257e4e44eaddcb836457.pdf - Дүрэм 35 - Санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдийн мэдээлэл https://umch.za.gov.mn/?page_id=296 - Ашиг алдагдлын мэдээлэл https://umch.za.gov.mn/?page_id=251 - Төсөвт оруулж буй татварын хэмжээ 17d69182a3aa9cf39e636a210e6a4322.pdf - Орон нутгийн өмчит газруудын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл /Овог нэр, эрхлэх албан тушаал, хаяг/ e6c74b689b411f7487c64f76b181e629.pdf - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулах журам 3ГТогтоол-2023-85 - Бүтэц орон тооны мэдээлэл - Үүсгэн байгуулсан болон өөрчлөн байгуулсан тогтоол https://zavkhan.gov.mn/upload/files/a923bf1f989dd9b41899958950d8cf53.pdf Орон нутгийн өмчит нийт 7 хуулийн этгээдийн 10 төрлийн мэдээллийг нийтэд нээлттэйгээр байршуулсан байна.
---	--	--	--	--	--

Зорилт 4. Орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох байгууллагуудыг бодлогын зөвлөгөө мэдээллээр хангах:

14	Арга хэмжээ 4.1 Аймгийн ИТХ, Аймгийн Засаг дарга, удирдлагуудад өмчийн харилцааны асуудлаар мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах	БӨХ	Танилцуулсан мэдээллийн тоо	0	4	- 2025 оны эхний хагас жилд Орон нутгийн өмчит байгууллагуудаас ирүүлсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн санал хүсэлтийг журмын дагуу Аймгийн ИТХ-ын зөвлөлөөр оруулан хэлэлцүүлж, аймгийн ИТХ-ын даргын 5 захирамж гаргуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. - Отгонтэнгэр рашаан сувиллын менежментийн гэрээний гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг Аймгийн Засаг даргад хүргүүлэв. - Аймгийн Төрийн аудитын газарт төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын эзэмшилд байгаа тээрийн хэрэгсэлийн тод дэвсгэр бүхий цэнхэр дугаарын судалгаа, дуусаагүй байрилгын судалгаа, шинээр төсөл арга хэмжээ нь зарлагдсан барилгын үлдэх өртгийн судалгаа, 2020-2024 оны буюу сүүлийн 5 жилийн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт, орлого зарлагын судалгаа зэрэг 4 төрлийн судалгааг гаргаж өгч мэдээллээр ханган ажиллалаа. - Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс болон ТӨБЗГ-т орон нутгийн өмчит 7 хуулийн этгээдийн хүний нөөц, санхүү эдийн засгийн байдал, удирдлага, орон тоо, ТУЗ-ийн мэдээллийг хүргүүлэн ажилласан. - Орон нутгийн өмчит “Завхан хөгжлийн корпорац” үйлдвэрийн газар байгуулах дүрмийн төсөлд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. - УИХ-ын гишүүн Цэнгүүний ирүүлсэн албан бичгийн дагуу Орон нутгийн өмчит компани болон үйлдвэрийн газруудын эдийн засгийн үзүүлэлтийн судалгааг хүргүүлсэн. - Аймгийн ИТХ-д орон нутгийн өмчит байгууллагуудын данснаас хасах, балансаас балансад шилжүүлэх, худалдах хөрөнгийн доод үнэ тогтоох хөрөнгүүдийн мэдээллийг таницуулж шийдвэрийг гаргуулсан.	100%
15	Арга хэмжээ 4.2 Төрийн болон орон нутгийн	БӨХ	Сургалт зөвлөмжийн тоо	0	2	- 2025 оны 4-р сарын 25-нд сумдын Санхүүгийн албаны дарга, мэргэжилтэн нарын сургалт, зөвлөгөөнд оролцож ахлах мэргэжилтэн Б.Бат-Амгалан “Орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, зохицуулалтын талаарх зарим асуудлууд” сэдэвт сургалт орж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. - 2025 оны 6 сард аймгийн “Эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага, санхүүгийн ажилтны зөвлөгөөн”-д оролцож	100%

	өмчит хуулийн этгээдийг өмчийн харилцааны асуудлаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, удирдлагаар хангах					мэргэжилтэн С.Шүрэнцэцэг “Өмчийн хөдөлгөөн, гарч буй алдаа дутагдал, анхаарах асуудал” сэдвээр сургалт орсон. - Орон нутгийн өмчит байгууллагын нягтлан бодогчид болон холбогдох албан тушаалтанд өмчийн хөдлөлт, өөрчлөлт тайлан мэдээтэй холбоотой мэдээллээр өдөр тутамдаа мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгч ажиллаж байна. - Сумдын орон нутгийн байгууллагуудын орон нутгийн хөрөнгө эзэмшүүлэх гэрээ дүгнэх, хяналт шалгалт хийхдээ тухайн байгууллагын удирдлага болон холбогдох албан хаагчдад хөрөнгийн хөдлөл өөрчлөлт, хөрөнгийн тооллого, ӨХБЗ-ийн үйл ажиллагааны талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах үүрэг чиглэлийг өгч ажиллаж байна.	
--	--	--	--	--	--	--	--

16	Арга хэмжээ 4.3 Өмчийн удирдлагын нэгдсэн системийн шинэчлэлийг нэвтрүүлэх	БӨХ	Сургалт, зөвлөмжийн тоо	0	8	Монгол улсын Засгийн газар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл удирдлага зохицуулалтын нэгдсэн цахим систем”-ийг бүрэн нэвтрүүлэх, 2025 оны 09 дүгээр сард багтаан иргэдэд нээлттэй болгох зорилт тавин системийн шинэчлэлийг хийж байгаатай холбоотойгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2025 оны 07 дугаар тушаалаар ажлын төлөвлөгөөг батлан ажиллаж байна. Тус төлөвлөгөөний дагуу 2024 оны жилийн эцсийн тайлан мэдээ хүлээн авах, шилжилтийн цахим систем, тайлан гаргах, бэлтгэхтэй холбоотой 6 удаагийн цахим сургалтыг орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн нягтлан бодогч, нярав нарт зохион байгуулсан. Өмчийн удирдлагын нэгдсэн системийн шинэчлэлийг нэвтрүүлэх ажлын хүрээнд https://umch.sgov.mn/ цахим программд бүртгэлтэй хөрөнгүүдийн зургийг 3 талаас нь авч үнэн зөв оруулах болон 2025 оны эхний хагас жилийн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг 7 сарын 1-ний дотор багтаан хийхийг орон нутгийн өмчит бүх байгууллагын дарга, эрхлэгч нарт албан бичиг хүргүүлэн, мөн хөрөнгийн хөдлөлт өөрчлөлтөд системээр хяналт шалгалтыг хийж хөрөнгийг актлах, үнэ шинэчлэн тогтоох, хөрөнгийн ангиллыг өөрчлөх, балансаас балансад шилжүүлэх ажлыг зохион байгуулж эхний хагас жилд багтаан гүйцэтгэхээр ажиллаж байна. 2025 оны 8-р сарын 25-аас 27 нд УБ хотод сургагч багш бэлтгэх сургалтад сүж бэлтгэгдсэн. Орон нутгийн өмчийн 195 байгууллагын 2025 оны 1-р сараас 9-сарын 20 хүртэлх хөдөлгөөний мэдээллийг одоогийн ашиглаж буй системд бүртгэх ажлыг зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллалаа. Одоогийн ашиглаж буй системээс шинэ мэдээллийн системд шилжих ажлыг зохион байгуулж байна.	100%
Зорилт 5. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, байгууллагын хүний нөөц, санхүүг үр ашигтай удирдах:							
17	Арга хэмжээ 5.1 Байгууллагын үйл ажиллагаанд хийх	БӨХ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	0	100%	Байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын 2025 оны төлөвлөгөөг байгууллагын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	70%

	хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг тайлагнах					Төлөвлөгөөний дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг 4 үйл ажиллагаанд хагас жилээр, дотоод хяналтыг 2 үйл ажиллагаанд улирал бүр буюу хагас жилд 2 удаа, 1 үйл ажиллагаанд хагас жилээр хийж, нийт 11 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийсэн байна.	
18	Арга хэмжээ 5.2 Байгууллагын хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, арга хэмжээний мэдээллийг аймгийн албан ёсны болон байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт тогтмол байршуулна.	БӨХ	Мэдээлэл шинэчилсэн тоо	0	4	Байгууллагын хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, арга хэмжээний мэдээллийг аймгийн албан ёсны сайт болон өөрийн байгууллагын сайт, мэдээллийн самбарт тогтмол байршуулж олон нийтэд мэдээлсэн. Үүнд: - Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн 10 төрлийн мэдээлэл - Нээлттэй дуудлага худалдааны 4 удаагийн зар мэдээлэл - Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн 23 мэдээлэл	100%
19	Арга хэмжээ 5.3 Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь бүрэн, ил тод мэдээлж тайлагнана.	БӨХ	Мэдээлэл байршуулсан тоог үзүүлэлтийн хувиар	100%	100%	https://info.shilendans.gov.mn/ веб сайтад төсвийн гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалттай холбоотой нийт 165 мэдээллийг хуулийн цаг хугацаанд нь байршуулан ажиллалаа.	100%
20	Арга хэмжээ 5.4 Аймгийн Засаг даргын захирамжаар баталсан графикийн дагуу мэдээ тайланг хугацаанд нь үнэн зөв тайлагнах	БӨХ	Графикт мэдээ тайлангийн хэрэгжилтийн хувиар	100%	100%	Батлагдсан графикийн дагуу мэдээ тайланг 3-р улирлаар үнэн зөв тайлагнасан. Үүнд: - Өргөдөл гомдлын мэдээ – 3 удаа - Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт –3 удаа - Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас, жилийн эцсийн биелэлт -1 удаа - Төрийн албан хаагчдад зэрэг дэв олгуулах санал -1 удаа - Төрийн албан хаагчийн сургалтын, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилт -1 удаа - Ёс зүйн дэд хорооны тайлан -1 удаа - Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын шийдвэрийн хэрэгжилт-1 удаа - Засгийн газрын зарим чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилт-1 удаа	100%

						- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт -1 удаа - Төсвийн гүйцэтгэлийн мэдээ – 9 удаа - Засгийн газрын зарим чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилт – 1 удаа - МУ-ын Ерөнхий сайдын 03, 04 тоот албан даалгаврын хэрэгжилт – 2 удаа /8сарын 20-оос хойш сар бүр/ - Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт – 1 удаа - Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний зөвлөмжийн тайлан – 1 удаа - ТӨБЗГ-т Засгийн газрын 481-р тогтоолын хэрэгжилт – 1 удаа Нийт 28 мэдээ тайланг хүргүүлэн ажилласан байна.	
21	Арга хэмжээ 5.5 Иргэдийн өргөдөл гомдлын хүлээн авч, судлан шийдвэрлэж, хариу өгөх, тайлагнах	БӨХ	өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь	100%	100%	- Байгууллагын албан хаагчдаас чөлөө авах хүсэлтэй 47 өргөдөл ирснийг шийдвэрлэсэн. - Хамтран ажилладаг байгууллага, иргэдээс өргөдөл гомдол ирээгүй.	100%
22	Арга хэмжээ 5.6 Албан хаагчдын сургалтын төлөвлөгөө, Нийгмийн баталгааны хөтөлбөр боловсруулан батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах	БӨХ	Хэрэгжилтийн хувь	100%	100%	Албан хаагчдын сургалтын төлөвлөгөө, Нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийн 2025 оны төлөвлөгөөг байгууллагын даргаар батлуулан мөрдөн ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг гаргаж аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлсэн. - 2025 оны Сургалтын төлөвлөгөөнд нийт 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан ба 7 арга хэмжээг 3-р улирлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Эхний 9 сарын байдлаар 7 арга хэмжээ хэрэгжсэн байна. - Нийгмийн баталгааны хөтөлбөрийн 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу 16 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж, гүйцэтгэлийн үнэлгээ 100% байна.	70%
23	Арга хэмжээ 5.7 Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөлт хэрэгжилтэнд	БӨХ	Явцын хяналтын тоо	4	4	Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд улирал бүрээр 3 удаа хяналт тавьж, үр дүнг үнэлэх ажлыг хууль журмын дагуу зохион байгуулсан.	100%

	хяналт тавьж,үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, ажлыг хууль журмын дагуу зохион байгуулах						
24	Арга хэмжээ 5.8 ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд тайлагнан хүргүүлсэн байх	БӨХ	Биелэлтийг хуулийн хугацаанд тайлагнасан байдал /хувиар/	100%	100%	Байгууллагын дарга, нягтлан бодогч нар ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн ажилласан.	100%
25	Арга хэмжээ 5.9 Байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтлөх,тайлагнах	БӨХ	Хугацаанд нь тайлагнасан байдал	100%	100%	2024 оны санхүүгийн жилийн эцсийн тайланг аудитын газраар баталгаажуулж зөрчилгүй дүгнэлт авсан. -2025 оны төсвийг хуваарийн дагуу зарцуулж гүйцэтгэлийн сарын мэдээг Санхүү төрийн сангийн хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлж байна. - 2025 оны эхний хагас жилийн тайлан, 2026 оны төсвийн төслийг гаргаж Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.	100%
26	Арга хэмжээ 5.10 Албан хэрэг хөтлөлт,архивын баримт бичгийн бүрдүүлэлт, нэгж үүсгэж хүлээлгэн өгсөн байдалд хяналт хийж, үр дүнг тооцно	БӨХ	Албан хэргийг хос бичгээр хөтлөж хэрэгжилтийг тайлагнах	100%	100%	2025 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагад нийт 82 албан бичиг ирж, үүнээс: хариутай 55, судлагдаж байгаа 28 албан бичиг байна. Албан бичгийн бүртгэлийг цаг тухай бүр хөтөлж, хариутай албан бичгийг цаг тухай бүрт шийдвэрлэн хариуг хүргүүлэн ажиллаж байна. Албан бичиг бүрийг хос бичгээр хөтөлж байна.	100%
27	Арга хэмжээ 5.11 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих	БӨХ	Тарьсан модны тоо, амьдралтын хувь	350	50	Аймгийн баяр наадмын талбайг зүлэгжүүлэх, мод тарих ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Өмнөх жилүүдэд тарьсан моддыг услах, арчлах, ургаагүй модыг авч дахин мод суулгах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна. 2025 онд нийт 15 мод шинээр суулгасан.	100%

Зорилт 6. Нэмэлт ажил								
№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилто т түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)	Гүйцэт гэлийн хувь
28	Төрийн албаны тухай хууль	Арга хэмжээ 6.1 Төрийн албан хаагчийг томилохдоо Төрийн албаны тухай хууль тогтоомжийг чанд мөрдөж, томилгооны зөрчилгүй ажиллах	БӨХ	Хэрэгжилтийн хувь	100%	100%	2025 оны 1-р сард Аймгийн Засаг даргын захирамжаар байгууллагын бүтэц орон тоонд өөрчлөлт орж 7 албан хаагчтай болсон. Баталсан бүтэц орон тоогоор ажиллаж байгаа ба томилгооны зөрчилгүй ажиллаж байна.	100%
29	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль	Арга хэмжээ 6.2 Байгууллагын ёс зүйн дэд хороог байгуулж ажлыг эрчимжүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиулах	БӨХ	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	100%	100%	Байгууллагын ёс зүйн дэд хорооны 2025 оны жилийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. - Баруун бүсийн орон нутгийн өмчийн газрын албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөний үеэр “Эерэг хандлагыг түгээе” нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. - Ёс зүйтэй албан хаагч шалгаруулах үзүүлэлтийг боловсруулж, байгууллагын даргаар батлуулсан. - Албан хаагчдын харилцаа хандлага, ёс зүйн талаар санал асуулга боловсруулан хамтран ажилладаг байгууллагуудаас судалгаа авч үр дүнг нэгтгэн гаргасан.	100%

							- ТАЗ, Ёс зүйн хорооны хамтран зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” баруун бүсийн зөвлөгөөнд ёс зүйн дэд хорооны дарга хамрагдаж, байгууллагын албан хаагчдад зөвлөгөөний мэдээллийг хүргэсэн. - www.csc.gov.mn сайтад ёс зүйн дэд хорооны төлөвлөгөө болон хэрэгжилтийн тайланг хуулийн хугацаанд оруулан ажиллаж байна.	
30	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон аймгийн Засаг даргын хооронд 2024 онд хамтран ажиллах гэрээ	Арга хэмжээ 6.3 Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагаанд цахим системийн хэрэглээг эрчимжүүлэх	БӨХ	Цахим систем ашиглаж буй албан хаагчдын эзлэх хувь	100%	100%	Албан хаагч нарын ажлын цагийн бүртгүүлэлт, албан бичгийн шийдвэрлэлт зэргийг ERP системээр гүйцэтгэн ажиллаж байна.	100%
31	Төрийн байгууллагын нэгдсэн системд холбогдох	Арга хэмжээ 6.4 gov.mn-д холбогдож мэдээлэл байршуулах	БӨХ	Мэдээлэл байршуулсан байдал	100%	100%	www.gov.mn цахим сайтад байгууллагаа бүртгүүлэн цаг тухай бүрт мэдээлэл байршуулсан. ➢ Нээлттэй дуудлага худалдаа ➢ Цаг үеийн мэдээллүүдийг байршуулж байна.	100%
32	Нийтийн мэдээллийн Ил тод байдлын нэгдсэн системд холбогдох	Арга хэмжээ 6.5 shilen.gov.mn-д холбогдож мэдээлэл байршуулах	БӨХ	Ил тод байдлын хэрэгжилтийн хувь	100%	100%	Аймгийн цахим хэлтсээс зохион байгуулсан www.shilen.gov.mn сайтад мэдээлэл байршуулах сургалтад хамрагдаж, тус сайтад байгууллагын мэдээллийг байршуулан I-II улирлын тайланг илгээсэн. 2025 оны хагас жилээр 84,0%-ийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн.	80%
33	АЗДҮАХ-3.4.2	Арга хэмжээ 6.6 MNS7002:2023 “байгаль орчны менежмент, ногоон ажлын байр – хэрэгжүүлэх арга зүйн заавар” үндэсний	БӨХ	Ногоон ажлын байрны стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байдал	100%	100%	Хүлээгдэж байна.	-

		стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх						
34	Хог хаягдлын тухай хууль, Аймгийн ИТХ-ын 2019 оны 56 тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны А/312 дугаар захирамж	Арга хэмжээ 6.7 Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгт үйл ажиллагаа явуулах аргачилсан зааврыг дагаж мөрдөх	БӨХ	Аргачилсан зааврын дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	100%	100%	2025 оны 05 дугаар сард өөрийн байгууллагад хуваарилагдсан газрын хогийг цэвэрлэж 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаал, "Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгт үйл ажиллагаа явуулах аргачилсан зааврыг дагаж мөрдөн ажиллаж хогийг хогийн цэгт буулгаж ажилласан.	70%
35	Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	Арга хэмжээ 6.8 Аймгийн Засаг дарга, удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь хэрэгжүүлж, тайланг Засаг даргын Тамгын газарт албан ёсоор ирүүлж байх	БӨХ	Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувиар	100%	100%	Аймгийн Засаг дарга удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүр хэрэгжүүлж тайлан мэдээг цахим системээр хүргүүлсэн.	100%
36	Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	Арга хэмжээ 6.9 Аймгаас зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээ, хурал, зөвлөгөөнд идэвхтэй оролцож, хэрэгжилтийг хангаж ажиллах	БӨХ	Хурал, зөвлөгөөн болон нэгдсэн арга хэмжээнд оролцсон ирцийн хувь	100%	100%	Дараах нэгдсэн арга хэмжээнд байгууллага хамт олноороо бүгд хамрагдсан. П. Очирбат агсан гэгээн дурсгалд хүндэтгэл үзүүлэх ёслолд 3 удаа оролцсон - УИХ-ын дарга Д.Амарбаясгалангын уулзалтад суусан. -УИХ-ын гишүүн Б. Түвшингийн уулзалтад суусан. - Гамшигаас урьдчилан сэргийлэх болон анхны тусламж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар сургалт, нээлттэй хаалганы өдөрлөгт оролцсон - “Эрүүл шүд” хөтөлбөрийн нээлтийн арга хэмжээнд оролцсон. - Номын сангийн өдөрлөгт хамрагдсан. - Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас зохион байгууллагаас зохион байгуулсан “Нэг ном- нэг сэтгэл” аянд нэгдсэн.	100%

							- “Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх V аян” сургалтад байгууллагын бүх ажилтан хамрагдсан. - “Хавдаргүй Монгол” аяны сургалт зөвлөгөөнд хамрагдсан.	
37	Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	Арга хэмжээ 6.10 Захиргааны үйл ажиллагаа, захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх зарчмыг баримталж, иргэн захиргааны байгууллагатай чөлөөтэй харилцах боломжийг бүрдүүлж ажиллах	БӨХ	Зөрчилгүй ажилласан байх	100%	100%	Хүний эрх, эрх чөлөөг дээдлэн зөрчилгүй ажиллаж байна.	100%
38	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйл	Арга хэмжээ 6.11 Жендэрийн дэд салбар зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллана	БӨХ	Хэрэгжилтийн хувь	100%	100%	Жендерийн дэд салбар зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөг батлуулан Завхан аймгийн дэд салбарт хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	70%
39	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйл	Арга хэмжээ 6.12 Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан "Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого"-ыг хэрэгжүүлэн ажиллана	БӨХ	Хэрэгжилтийн хувь	100%	100%	"Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого"-ыг хэрэгжүүлэн албан хаагчдын эрх тэгш байдлыг ханган ажиллаж байна. Хоол унааны хөнгөлөлт, урамшуулал зэрэгт тэгш хамрагдаж байна.	70%
40			БӨХ	Хэрэгжилтийн хувь	100%	100%	2025 оны Жендерийн дэд салбар зөвлөлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.	70%

	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйл	Арга хэмжээ 6.13 "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)"-ийг хэрэгжүүлэн ажиллах ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллана					Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн дундаж насжилтын зөрүүг ойртуулах зорилтын хүрээнд: • 7 хоногт 1 удаа 2 цагаар спорт заал түрээслэж байна. • Эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт жилд нэг удаа хамруулж байна. • Бие бялдрын сорилд хамрагдсан. • Эрүүл мэндийн төрөл бүрийн 3 удаагийн сургалтад хамрагдсан. /Зөв хооллолт, хорт зуршлаас ангид байх/ • Хавдаргүй Монгол” аяны эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан. • Жендерийн бодлогоор уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах нь” бүсийн зөвлөгөөнд хамрагдсан.	
41	Ахмад настны тухай хуулийн 14.7.	Арга хэмжээ 6.14 Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг "Ахмадын сан"-д төвлөрүүлэн ажиллана.	БӨХ	Хэрэгжилтийн хувь	100%	100%	Ахмадын сангийн журам-ыг баталсан. Санг байгуулсан.	50%
42	Ахмад настны тухай хуулийн 11.1.1.	Арга хэмжээ 6.15 Ажилтныг тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	БӨХ	Хэрэгжилтийн хувь	-	100	Тухайн онд болон дараагийн 3 жилд тэтгэвэрт гарах албан хаагч байхгүй тул 2027 оноос тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллана.	70%
43	Ахмад настны тухай хуулийн 14.6	Арга хэмжээ 6.16 Ахмадын өргөө, танхим, төвийн үйл ажиллагааг өргөжүүлэн ахмад настны хөдөлмөр	БӨХ	Хэрэгжилтийн хувь	-	100	Хүлээгдэж байна.	-

		эрхлэлт, нийгэм, соёлын үйл ажиллагааг дэмжин ажиллана.						
44	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль	Арга хэмжээ 6.17 Хөгжлийн бэрхшээлтэй хүний орчин саадгүй, хүртээмжтэй байдлыг хангах	БӨХ	Хэрэгжилтийн хувь	0	100	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжтэй байдлыг ханган ажиллаж байна.	70%
45	Аймгийн Засаг даргын 2023 оны 04-р албан даалгаварын хэрэгжилт	Арга хэмжээ 6.18 Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах	БӨХ	Хэрэгжилтийн хувь	100%	100%	Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангаж албан бичгийг хос бичгээр хөтөлж байна.	100%
46	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр	Арга хэмжээ 6.19 Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэн тайлагнах	БӨХ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	100%	100%	Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг байгууллагын даргаар батлуулан мөрдөн ажиллаж байна. Нийт 4 зорилтын хүрээнд 11 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж хагас жилийн хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлэн ажиллалаа.	80%
47	Хүний эрхийг хангах үндэсний хорооны 2023 оны 01 дүгээр тогтоол	Арга хэмжээ 6.20 Хүний эрхийг хангаж, төлөв байдлын тайлан гаргаж хугацаанд нь ирүүлэх	БӨХ	Хугацаанд нь тайлагнасан байдал	100%	100%	IV улиралд төлөвлөгдсөн хүлээгдэж байна.	-
48	АЗДҮАХ 4.1.3.3	Арга хэмжээ 6.21 Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн дуудлага худалдааг цахимаар зохион байгуулах	БӨХ	Хэрэгжилтийн хувь	0	100%	IV улиралд төлөвлөгдсөн хүлээгдэж байна.	-
49	АЗДҮАХ 4.3.1.2	Арга хэмжээ 6.22 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтын хугацаа дууссан эд хөрөнгийн мэдээллийн цахим сан үүсгэж	БӨХ	Хэрэгжилтийн хувь	0	100%	IV улиралд төлөвлөгдсөн хүлээгдэж байна.	-

		нийтэд нээлттэй болгож эдийн засгийн эргэлтэд оруулах						
	Хэрэгжсэн арга хэмжээний тоо							42
	Гүйцэтгэлийн дундаж хувь							90,0%

Төлөвлөгөө тайлагнасан:

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН

ГАЗРЫН ДАРГА

(албан тушаал)

Тэмдэг

Төсвийн Шууд захирагч



Д.БАТМЭНД